



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# **“Ардчилсан засаглал судалгаа”-ны 2013, 2014 оны үр дүн**

УЛААНБААТАР 2015

## АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

“Ардчилсан засаглал” судалгааг 2008 оны III улирлаас эхлэн явуулж байна. Ингэснээр, МХЗ-ын 60, 62, 67-р шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд байнгын давтамжтайгаар тооцох боломжтой болсон.

### 1. Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 60-р шалгуур үзүүлэлт)

2014 оны “Ардчилсан засаглал” судалгааны дүнгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрөөс хараат бус байдаг гэдэгтэй судалгаанд хамрагдсан иргэдийн 40.7 хувь нь санал нийлдэггүй, 23.0 хувь нь дунд зэрэг, 11.8 хувь нь санал нийлдэг гэж хариулсан байна. Мөн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс нилээд хараат байна гэж иргэдийн дийлэнхи үзэж байгаа нь нийт авбал зохих онооны дөнгөж дөрөвний нэгийг авч байгаагаар илэрхийлэгдэж байна /Хүснэгт 1/.

#### Хүснэгт 1

### Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл

	Хариулт, хувь												Үнэлгээ	
	Огт нийлдэггүй		Нийлдэггүй		Дунд зэрэг		Нийлдэг		Бүрэн нийлдэг		Мэдэхгүй			
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус байдаг	11.5	10.4	30.6	30.3	24.5	23.0	11.5	9.7	1.6	2.1	20.3	24.5	24	23
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг	10.2	9.6	28.2	29.1	24.1	23.6	10.9	8.9	1.6	1.9	25.1	27.0	24	22
Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг	6.6	7.1	15.9	19.7	30.4	29.7	35.2	31.1	6.5	5.0	5.5	7.4	65	57

Судалгаанд хамрагдсан иргэдийн 27.0 хувь нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байгаа эсэхийг “мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн нь өнгөрсөн оноос 1.9 пунктээр өссөн байна. Өөрөөр хэлбэл иргэд дээрх асуултын хувьд эргэлзээтэй, дундаж төсөөлөлтэй байгаа юм. “Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг” гэсэн хариултад судалгаанд хамрагдагсад 57 оноо өгсөн байна.

Иргэд олон нийтийн мэдээллийн байгууллагаас Монголын үндэсний телевизэд 92, үндэсний радиод 85, орон нутгийн телевизэд 81, хувийн телевизэд 79, FM радиод 65, өдөр тутмын хэвлэлд 73 гэсэн үнэлгээ өгсөн нь өнгөрсөн оноос 2-11 оноогоор буурсан байна. Харин шар хэвлэлийн хувьд 38 оноо өгсөн нь иргэд шар хэвлэлд бараг итгэдэггүй болох нь харагдаж байгаа бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад шар хэвлэлд итгэх итгэл 6 оноогоор буурсан хандлага ажиглагдаж байна. /Хүснэгт 2/.

## Хүснэгт 2

### Хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн хувь

Байгууллага	Хариулт, хувь												Үнэлгээ	
	Огт итгэдэггүй		Итгэдэггүй		Дунд зэрэг		Итгэдэг		Бүрэн итгэдэг		Мэдэхгүй			
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Үндэсний радио	1.4	1.9	4.6	7.6	21.8	24.4	46.8	43.6	11.2	8.9	14.3	13.7	91	85
FM радио /богино долгионы/	1.8	2.5	8.1	11.4	29.8	29.1	26.8	22.3	5.0	3.7	28.6	31.1	76	65
Монголын үндэсний олон нийтийн телевиз	0.8	1.2	3.6	4.7	20.1	20.5	53.6	55.8	18.4	13.8	3.5	4.0	94	92
Хувийн телевиз	1.6	2.1	8.0	9.4	34.1	34.7	37.5	36.4	7.4	5.6	11.5	11.9	82	79
Орон нутгийн телевиз	1.6	1.8	5.4	6.3	25.4	23.2	31.9	29.0	6.4	5.4	29.2	34.3	85	81
Өдөр тутмын хэвлэл	2.1	2.5	8.6	9.7	31.7	30.9	29.7	28.1	5.4	4.0	22.5	24.8	77	73
Шар хэвлэл	5.9	7.5	20.3	19.3	27.0	27.9	15.0	13.6	3.7	3.1	28.1	28.6	42	38

2014 оны жилийн эцсийн судалгааны дүнгээр хэвлэл, мэдээллийн байгууллагуудад иргэд 86 оноо өгсөн байгаа нь өмнөх оныхоос 1 оноогоор буурсан байна /Хүснэгт 3/.

## Хүснэгт 3

### Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын талаарх үнэлгээ

Байгууллага	Хариулт, хувь												Үнэлгээ	
	Маш муу		Тааруу		Дунд зэрэг		Сайн		Маш сайн		Мэдэхгүй			
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	2.1	1.7	7.1	7.0	25.1	28.9	49.6	48.0	9.6	7.7	6.6	6.7	87	86

### 2. Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 62-р шалгуур үзүүлэлт)

Төрийн захиргааны дээд байгууллагууд, түүний дотор хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх олон нийтийн төсөөлөл нь хүн амын дунд засаг, төрийн байгууллагуудад итгэл хүлээлгэж (үл хүлээлгэж) буй иргэдийн эзлэх хувь, түүнчлэн хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээг илэрхийлсэн үзүүлэлт юм.

2014 оны “Ардчилсан засаглал” судалгааны дүнгээр төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл:

Судалгаанд хамрагдсан иргэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, улсын сургууль, хувийн эмнэлэг, нийгмийн даатгал, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл ханамж хамгийн өндөр /86-89 оноо/ байгаа нь өмнөх оныхоос мөн үеийнхтэй ижил хандлагатай байна. Ерөнхийлөгчид өгсөн оноо өнгөрсөн оноос 4, УИХ 94, Засгийн газар 12 оноогоор тус тус буурсан байна. /Хүснэгт 4/.

## Хүснэгт 4

### Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөлөл

	Хариулт, хувь												Үнэлгээ	
	Маш муу		Тааруу		Дунд зэрэг		Сайн		Маш сайн		Мэдэхгүй			
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Ерөнхийлөгч	3.3	3.8	12.2	13.6	37.4	39.5	36.0	33.5	6.8	4.5	4.4	5.2	73	69
УИХ	5.1	6.8	19.3	23.3	46.4	44.0	20.4	18.1	3.2	2.1	5.5	5.8	49	40
Засгийн газар	4.2	7.6	17.1	22.2	43.5	42.1	25.1	19.6	3.8	2.3	6.3	6.3	58	42
Улс төрийн намууд	7.1	8.4	24.3	25.1	39.1	39.2	14.7	12.5	1.7	1.8	13.0	13.1	34	30
Иргэний нийгмийн байгууллагууд /төрийн бус байгууллага/	3.6	3.5	15.8	17.7	34.8	36.2	23.4	18.5	2.8	2.9	19.7	21.3	57	50
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	2.1	1.7	7.1	7.0	25.1	28.9	49.6	48.0	9.6	7.7	6.6	6.7	87	86
Нийслэл/ аймгийн ИТХ	2.4	3.0	10.5	11.6	31.7	31.9	25.6	22.1	2.8	2.4	27.1	29.0	69	63
Дүүрэг/сумын ИТХ	3.2	3.6	12.2	12.6	35.3	33.4	25.9	23.3	2.8	2.7	20.7	24.5	65	62
Хороо/ багийн Иргэдийн Нийтийн Хурал	4.5	5.0	13.6	13.4	33.3	30.0	28.0	27.8	4.1	3.3	16.5	20.5	64	63
Нийслэл/ аймгийн Засаг дарга	2.4	2.5	9.0	8.8	28.4	30.9	35.2	35.0	6.6	5.6	18.4	17.3	79	78
Дүүрэг/ сумын Засаг дарга	3.0	2.7	10.8	10.4	31.7	34.6	34.0	33.0	5.3	4.3	15.2	15.0	74	74
Хороо/ багийн Засаг дарга	3.5	3.4	11.2	11.0	27.7	31.1	41.1	41.2	7.0	5.2	9.5	8.1	77	76
Дээд шүүх	3.4	2.3	8.7	8.7	22.5	23.8	15.3	14.3	3.2	3.0	46.9	48.0	60	61
Нийслэл/ аймгийн шүүх	3.1	2.1	8.5	8.6	23.5	24.9	15.4	14.6	2.8	2.7	46.7	47.2	61	62
Дүүрэг/сум дундын шүүх	3.4	1.9	8.2	8.9	24.2	25.2	14.8	14.5	2.4	2.5	47.1	47.0	60	61
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар	3.0	2.2	8.0	8.2	23.0	25.0	16.0	15.7	3.3	2.4	46.7	46.5	64	64
Замын цагдаа	2.7	2.7	8.7	7.9	28.3	28.2	39.0	35.7	5.7	4.8	15.6	20.8	80	79
Эрүүгийн цагдаа	2.6	2.5	9.4	9.2	29.8	30.6	30.8	28.1	4.7	3.9	22.8	25.7	75	73
Хэв журмын цагдаа	2.8	2.2	9.9	9.0	30.0	30.3	32.0	30.7	5.5	4.6	19.7	23.2	75	76
Авилгатай тэмцэх газар	4.6	4.5	11.8	11.7	23.7	26.2	22.7	21.6	5.5	3.9	31.6	32.1	63	61
Мэргэжлийн хяналтын газар	4.6	3.6	12.6	12.6	28.4	29.0	22.7	21.7	2.9	3.7	28.8	29.5	60	61
Аудитын газар	2.9	1.6	7.3	6.4	23.3	23.5	19.5	19.1	3.0	3.2	44.0	46.2	69	73
Гаалийн байгууллагууд	3.4	2.7	8.2	8.6	22.0	24.5	21.0	20.0	2.5	2.8	43.0	41.5	67	67
Газрын албад	7.9	7.3	19.1	16.1	27.7	29.7	20.2	19.2	2.1	3.1	23.0	24.6	45	49
Татварын байгууллагууд	2.2	1.7	6.4	6.4	27.1	29.3	33.3	32.8	4.8	4.6	26.2	25.2	82	82
Нийгмийн даатгалын байгууллагууд	1.4	1.2	4.1	5.2	21.1	25.4	52.3	45.5	8.8	6.3	12.3	16.5	92	89
Нийгмийн халамжийн байгууллагууд	1.5	1.4	5.3	5.7	21.4	26.3	51.2	44.9	8.7	6.2	11.9	15.5	90	88
Улсын сургууль	1.5	1.3	6.4	5.6	26.7	26.9	46.7	46.2	8.2	7.3	10.5	12.8	87	89
Хувийн сургууль	1.8	1.4	7.2	6.1	25.4	24.5	30.0	30.7	6.9	6.5	28.7	30.9	80	83
Улсын эмнэлэг	5.2	3.9	13.7	11.3	31.1	31.8	37.9	39.0	6.4	7.1	5.8	6.8	70	75
Хувийн эмнэлэг	1.6	1.1	6.1	5.1	21.9	23.1	40.9	43.0	9.0	8.6	20.5	19.2	87	89

## Хүснэгт 5

### Төр, захиргааны байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа хүн амын эзлэх хувь

Байгууллага	Хариулт, хувь												Үнэлгээ	
	Огт итгэдэггүй		Итгэдэггүй		Дунд зэрэг		Итгэдэг		Бүрэн итгэдэг		Мэдэхгүй			
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
УИХ	5.7	7.2	20.3	26.5	43.7	41.5	22.0	16.6	2.4	2.2	5.8	6.0	48	36
Засгийн газар	4.4	6.5	18.4	26.5	43.0	41.6	25.1	17.1	3.0	2.4	6.1	6.0	55	37
Ерөнхийлөгч	4.7	5.4	16.0	19.6	35.2	37.8	32.8	28.3	6.6	4.0	4.7	5.0	66	56

Иргэдээс ерөнхийлөгч, УИХ болон Засгийн газарт хүлээлгэж байгаа итгэл 36-56 оноотой байгаа нь өмнөх онтой харьцуулбал УИХ 8, Засгийн газар 18, Ерөнхийлөгч 10

оноогоор буурсан байгаа нь тэдэнд хүлээлгэж байгаа ард түмний итгэл суларсан байгаа нь харагдаж байна.

### 3. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 67-р шалгуур үзүүлэлт)

Судалгаанд оролцсон иргэдээс сүүлийн 12 сард төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагаас авсан үйлчилгээг асууж “тийм” гэж хариулсан иргэдээс үйлчилгээ авах үед авлига ажиглагдсан эсэхийг тодруулж асуусан юм.

#### Хүснэгт 6

#### Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига байгаа эсэх талаарх иргэдийн төсөөлөл

Үйл ажиллагаа	Хариулт, хувь			
	Сүүлийн 12 сард үйлчилгээ авсан иргэдийн хувь		Үйлчилгээ авах үед авлигын асуудлыг анзаарсан иргэдийн хувь	
	2013	2014	2013	2014
Ажилд оруулах /өөрөө болон бусдыг, төрийн албанд/	13.4	9.4	4.6	2.8
Хүүхэд сургуульд оруулах	23.5	18.6	4.2	2.4
Курс болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах	9.4	3.8	1.3	0.6
Сургалтын дүн тавиулах	6.7	4.9	1.8	0.8
Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлуудыг шийдэх (Автын үзлэг, оношлогоо гэх мэт)	27.5	26.7	4.0	3.5
Эмнэлгийн үйлчилгээ авах	61.3	55.8	9.1	7.7
Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт авах	55.9	50.3	1.3	2.0
Цэргийн албанаас чөлөөлөгдөх	5.7	3.1	1.0	0.5
Нийгмийн халамж, тусламж, үйлчилгээ авах	32.1	21.3	1.8	1.5
Төсөл, зээл, тусламжид хамрагдах	12.3	8.2	2.1	1.6
Банкнаас зээл авах	34.7	31.4	1.7	2.0
Газрын зөвшөөрөл авах	14.8	9.1	4.0	2.7
Гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх	2.1	0.8	0.8	0.3
Татвараас хөнгөлөх, чөлөөлөх/гаалийн татвараас бусад/	2.7	1.2	0.6	0.3
Шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх	2.4	1.2	1.0	0.5
Хилээр их хэмжээний бараа оруулах, гаргах	2.0	1.1	0.6	0.3
Паспорт авах /Дотоод, Гадаад/	24.1	7.4	1.0	0.5
Виз авах	4.4	2.4	0.8	0.5
Хэргийг аль нэг шатанд хэрэгсэхгүй болгох	1.2	0.6	0.4	0.3
Тусгай зөвшөөрөл лиценз авах	2.2	0.9	1.0	0.3
Тендерийн шалгаруулалтад нөлөөлөх	1.6	0.7	0.7	0.3
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийлгэх	5.9	2.7	1.0	0.8

Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига байгаа эсэх талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл, судалгаанд хамрагдагсдын 60-аас дээш хувь нь сүүлийн 12 сард эмнэлгийн үйлчилгээнд, 50-иас дээш хувь нь баг, хорооны засаг даргын тодорхойлолт авсан байна /Хүснэгт 6/.

Сүүлийн 12 сард төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 7.7 хувь нь эмнэлгийн үйлчилгээ авахад, 3.5 хувь нь тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал шийдвэрлэх үйлчилгээ авах үедээ авлига ажиглагдсан гэж хариулсан нь бусад чиглэлийн үйл ажиллагааныхаас илүү байна.